

Би зүгээр л оюутан баймаар байна

ХИС-ийн Сэтгүүл зүйн II-р курсийн оюутан Х. Дэлгэрмөрөн

Анхны Ажлын Дурсамж: Бариста

Tous le Jour bakery-д ажиллах нь эхэндээ романтик ч юм шиг санагдсан. Цонхны цаанаас гэрэлтэх гудамж, кофены үнэр, амтат талх, нарийн боовны анхилуун үнэр... Багагүй хүсэл, найдвар тээж, хүмүүсийг баярлуулж байгаагаа мэдрэх тэр мөчүүд надад амьдралын нэгэн амтыг өгч байлаа. Гэвч бодит байдал өөр байв. Ёстой л шинэ бүхэнтэй гайхашран танилцаад л шантрах нь битгий хэл ядарч байгаа биеээ ч мэдэрсэнгүй

Үүрэг нь ердөө кофе найруулах, касс дээр зогсох мэтээр төсөөлж байсан ажил маань тэс өөр зүйл намайг хүлээж байсан. Өглөө есөн цагаас эхэлж шөнө 22, заримдаа бүтэн цаг сунаж ажиллаад тарах өдрүүд олон гарна. Байнга зогсоно. Төрөл бүрийн кофе, цай найруулах, касс дээр зогсох, хүмүүсийн захиалгыг бэлдэх, торт хайрцаглах, 300-400 гаруй нэр төрлийн бүгд өөр өөрийн хэлбэр хэмжээтэй кекс, донат, талхнуудыг уутлах, хяналт тавих, орой тарахдаа дэлгүүрээ бүрэн цэвэрлэх гээд хязгааргүй их ажил байв. Энэ бүхнийг долоо хоногийн 3-4 өдөр ажиллах боломжтой гэж хууран өөртөө тайлбарлаж байсан ч амьдралын эрч хүчийг минь сорох мэт санагдаж байлаа.

Өдөрт 35,000 төгрөг авч, сард 420,000 орчим төгрөгийн цалинтай ч мөртлөө, сар бүрийн дутсан барааны төлбөр, алдаатай тооцоо зэргээс болоод сарын эцэст 50,000-80,000 орчим төгрөг суутгуулдаг байсан нь хамгийн хамгийн хэсэг нь. Оюутны амьдралыг хөнгөхөн төсөөлж байсан маань бодит амьдралд намайг таарахгүй үүрэг даалгавар, хэтэрсэн ажил, сул цалин, дарамттай орчинд албадан зүтгүүлж байсан юм. Монголын ёс гурав гэж яг л байна шүү. Ажлын дөрөв дэхь өдрөөс нэг л бишдээд эхэлсэн. Сульдаад ч байх шиг, би зүгээр л оюутан баймаар байна. Гэлээ гэвч ажлаас гарна гэж яасан ч хэлж болохгүй.

Хамгийн харамсалтай нь оюутан ажилчдад зориулсан “цоорхойтой” гэрээнүүд байнга таардаг байв. “Хугацааны гэрээт ажил” нэрийн дор бидний хөдөлмөрийг шулж, цагт 4-5 цагийн турш завсарлагагүй ажиллуулах нь энгийн үзэгдэл.

Үйлчлүүлэгчид ч амаргүй, ихэд элдэвтэй. Ууртай, яарсан, ямар нэг зүйлд сэтгэл нь хангалуун бус байгаа хүмүүс бидэнтэй харьцахдаа бүдүүлэг, дээрэлхүү байдаг. Бид зөвхөн зөөгч, бариста биш, тэдний бухимдлаа гаргах золиос шиг санагдах үе ч байдаг. Нэг өдөр үйлчлүүлэгчийнхээ захиалгыг санамсаргүйгээр андуурахад л тэрээр над руу чанга дуугаар уурлав. Бүр нэг зэвүүцсэн харцаар ширтэж, “Энэ зэргийн ажлыг хийж чадахгүй байж яах гэж энд зогсож байгаа юм?” гэж зандрангүй хэлэхэд дотор минь хөндүүрлэв. Хүн зодоогүй атлаа яс махандаа мэдэрчихсэн тийм л сонин муухай хүчтэй мэдрүүлсэн ажил байлаа.

Энэ бүхний эцэст миний хүсэл тэмүүлэл алга болж, ажил хийх дургүй болов. Ингээд ажлаас гарна гэж уйлах нь шахам гуйн барин энэхүү чимээгүй дээрэлхэлтээс ангижрав.

Дараагийн ажил: Тансаг дэлгүүрийн “тансаг” шаналал

II-р курстээ өөрт тохирсон, ачаалал цалин хоёроо тэнцвэржүүлж чадсан ажил хийх төлөвлөгөөтэйгөөр эргэн ирсэн. Арай бага цагаар ажиллах буюу долоо хоногийн 1-2 өдөр Avant Cashmere дэлгүүрт худалдааны зөвлөхөөр ажиллах боломж олов. Миний төсөөллөөр энэ бол тайван, хөнгөн, ажиллах орчин нөхцөл таатай ажил байлаа. Долоо хоногийн ердөө 2 өдөр ажиллана, мөн дэгжин, тансаг үйлчлүүлэгчидтэй харилцана гэж бодсон. Гэвч энэ ажилд орсон эхний өдрөөсөө л урам хугарав.

Cashmere-ийн дэлгүүр учраас ажилчдаас маш өндөр хариуцлага хүсдэг, ихэнх үйлчлүүлэгчид мөнгөтэй хүмүүс болохоор. Үйлчлүүлэгчид маань бараг л бүгд өөрсдийгөө хаан, хатан мэтээр хүндлүүлэхийг шаардаж, нэг хүндлэлд хүрэхийн тулд хэдэн цагийн турш тэвчээртэй байх хэрэгтэй болдог байв. Зарим үйлчлүүлэгч зүгээр ч нэг зөвлөгөө авахгүй, харин ч хүнийг доош хийх, ажиллах орчинд шүүмжлэл үлдээх мэтээр бүдүүлэг хандлага гаргана. Худалдааны зөвлөхийн ажил үйлчлүүлэгчтэй харилцахад илүү нарийн арга барил, харилцааны ур чадвар шаарддаг байлаа. Үйлчлүүлэгчид cashmere бүтээгдэхүүнийг худалдан авахдаа материал, чанар, загварын талаар ихэд нарийн асууж шалгаана. Дахиад л биш. Цалингийн хэмжээ, ажиллах нөхцөл байдлыг эргэцүүлэн бодож эхэлсэн. Дэлгүүрийн удирдлага биднээс зарагдаж буй бүтээгдэхүүн бүрийг нэвт мэдэж, үйлчлүүлэгчдэд хэрхэн борлуулах талаар мэргэжлийн төвшинд мэдээлэлтэй байхыг хүснэ. Гэтэл бидэнд өгдөг цалин хөлс, хөнгөлөлтүүд нь энэ их хичээл зүтгэлийг дүйцэхгүй. Оюутнуудаар хямд хөдөлмөр хийлгэж, ашиг хонжоо олох зорилготой мэт санагдсан.

Камерын хяналтанд байнга байлгаж, ямар нэгэн жижиг зүйл дээр ч алдаа гаргахад л хурдан засах шаардлага тавьдаг байсан нь сүүлдээ ажиллах урам, сэтгэл гутраах шалтгаан болж байв. Өдөрт 11 цаг ажиллаж, 65,000 төгрөгийн хөлс авна. Өглөөний 9 цагаас оройны 8 цаг хүртэл дэлгүүрийн бүх л үйл ажиллагааг хариуцаж, цайны цагийн хуваарь шал худлаа. Ариун цэврийн өрөөнд 5 минут ч орох эрх үгүй үе олон гарч, стресс уур бухимдалтайгаа байнга нүүр тулдаг болсон, заримдаа өөрийн мэдэлгүй нулимс ч урсах шиг.

Үнэтэй туршлага

Эдгээр хоёр ажил намайг хүнд ажиллах нөхцөл, сул цалин хөлс, дарамт шахалтын орчинд ажиллах ямар байдгийг маш сайн ойлгуулсан юм. Би хичээл номоо халтар хултар хийж, оюутан цагийнхаа хамгийн үнэ цэнэтэй мөчүүдийг алдаж байгаагаа мэдэрсэн. Цагийн ажил оюутанд суралцах орчноос минь таслаж, стресс бухимдал дунд амьдрахад хүргэж байв.

Өнөөдрийн нөхцөлд олон оюутнууд өөрийн мөрөөдөл, сонирхлоо хойш тавин ажилд орж байгаа ч энэ нь бидний ирээдүйн чадамжид хэр их хор хөнөөл учруулж буйг бид ухаарах хэрэгтэй юм шиг санагддаг. Оюутан байхад цагийн ажил хийж, амьдралын мөн чанарыг ойлгож, хөдөлмөрийн үнэ цэнийг мэдэх нь чухал. Гэхдээ үүний хажуугаар бид хичээлдээ илүү анхаарч, суралцан мэдлэгээ сайжруулж, оюутны амьдралын онцгой сайхан мөчүүдийг алдах ёсгүй юм.

Мэдээж хэрэг цагийн ажил бол дэлхий нийтэд байдаг жишиг. Гэхдээ оюутан хүнд сурах зорилго нь эн тэргүүнд байх ёстой. Тиймдээ ч олон улсад оюутнууд долоо хоногт хамгийн ихдээ хэдэн цаг ажиллахыг тогтоосон байдаг. Жишээлбэл, Америкийн Нэгдсэн Улсад оюутан хүн хичээллэх хугацаанд долоо хоногт хамгийн ихдээ 20 цаг, улирлын амралт таарсан үед долоо хоногт 40 цаг ажиллахыг зөвшөөрдөг. Гэтэл манай улсад энэ төрлийн стандарт мөрдөгдөхгүй байгаагаас оюутнуудын сурлагын чанараас эхлээд бие, сэтгэл санааны эрүүл мэндэд ч сөргөөр нөлөөлж байна. Эдгээр туршлага надад нэг зүйлийг гүнзгий ойлгуулсан: оюутан байх үедээ зөвхөн мөнгөний төлөө бүхнээ золиослох шаардлагагүй юм байна. Хөдөлмөрийн үнэлэмж гэдэг нь зөвхөн цалингаас хамаарах зүйл биш, харин бидний үнэт зүйлс, амьдралын утга учиртай ч хамаатай. Оюутан нас бол өөрийгөө таньж, мөрөөдөлдөө хүрэх замналын эхлэл. Энэ насандаа ажил хийж туршлага хуримтлуулах нь чухал ч, өөрийгөө оюутан байхын жаргалтай мөчүүдээс хэт их золиослох нь амьдралын үнэ цэнтэй хэсгээ алдаж байгаа мэт санагддаг.

Оюутан насны шагналт, урамшуулал

Өөрийн суралцдаг мэргэжлээр жишээ татах юм бол Сэтгүүлзүйн чиглэлээр суралцаж буй оюутнуудын дунд олон сонирхолтой уралдаан тэмцээнүүд зохион байгуулагддаг. “Алтан үзэг” бол залуу бичигчид, сэтгүүлчид өөрсдийгөө сорих, бусдад өөрийгөө харуулах, өөрийн санааг нийгэмд түгээх нэгэн гайхалтай боломж юм. Эдгээр уралдаанд оролцож, бүтээлээ танилцуулан, нэр төртэй шагналын сантай байх боломж нь хичээлээ хийж, өөрийгөө хөгжүүлж, мөнгөний дарамтанд орохгүйгээр амьдралын үнэ цэнийг ойлгох зам юм. Өөрийн туршлагаас хуваалцвал, өмнөх шигээ 7 хоногт 40 цаг биш дөрөвхөн цагт, нэг өдрийн цалингаа олдог болсон. Монголын баримт шалгах төвөөс оюутнуудад энэхүү боломжийг олгодог. Энэ мэтчилэн нэг цаг үеэ бодоход оюутнуудыг дэмжсэн тэтгэлэгт уралдаан тэмцээнүүд хангалтай болсон.

Эцсийн бодрол: Оюутан насаа өөртөө амьдралын туршид нэг удаа өгөгдсөн шагнал мэтээр хүлээн авч, энэ он жилүүдээ хэтэрхий их ажлын дарамтаар хязгаарлалгүй, шинэ туршлага, боломжуудад нээлттэй байгаарай гэж хэлэх байна. Оюутан насныхаа онцгой сайхан мөчүүдийг алдалгүй өнгөрүүлж, хойшид өөртөө баяртайгаар дурсах он жилүүдийг бүтээхийг хичээх юм шүү.

Оюутан болохыг хэрхэн мөрөөдөж байснаа та санаж байна уу? Сургуулийн хонхны дуутай хамт гүйж гарч, амьдралын шинэ хуудас эргүүлэх тэр мөчийг бид ямар их догдлон хүлээсэн билээ. Арван жилдээ оюутны амьдралыг төсөөлж, найзуудтайгаа шөнөжин сууж хичээл хийх, чөлөөт цагаа хүссэнээрээ өнгөрүүлэх, шинэ орчин, шинэ хүмүүстэй танилцаж, өөрийнхөө мөрөөдлийг биелүүлэх тухай бодон, зүүдэлдэг байсан минь саяхан мэт. Гэвч бодит амьдралд үүнийг биелүүлэхэд үнэхээр хэцүү гэдгийг удахгүй ойлгох болно гэж хэн ч хэлээгүй.